

БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ: ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Мэдээллийн товхимол



Удиртгал	3
Бүлэг 1. 2019 оны Дэлхийн эрүүл мэндийн өдрийн тухай	3
1.1 Танилцуулга	3
1.2 Гол мессежүүд	4
1.3 Үйл хэрэгт уриалан дуудах нь	4
Бүлэг 2. Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт	5
2.1 Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт гэж вэ?	5
2.2 Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт нь ...гэсэн үг биш	6
2.3 Улс орнууд бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хэрхэн ахиц гаргах вэ?	6
Бүлэг 3. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	6
3.1 Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ гэж юу вэ?	6
3.2 Яагаад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ чухал вэ?	7
3.3 Астанагийн Тунхаглал	8
Ашигласан хэвлэлийн жагсаалт	10

Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт гэдэг нь хүн бүр эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг хэрэгцээтэй үедээ, хаана амьдарч байгаагаас үл хамааран санхүүгийн хүндрэлгүйгээр авах боломжтой байхыг хэлнэ. Энэ нь эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх, хөнгөвчлөх зэрэг хүний амьдралын туршид шаардлагатай тусламж үйлчилгээг бүрэн хэмжээгээр агуулсан бөгөөд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүчирхэг тогтолцоонд суурилсан байдаг.	
Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх зорилтыг 2015 онд дэлхийн улс орнууд Тогтвортой хөгжлийн зорилтуудыг тодорхойлохдоо дэвшүүлсэн нь Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэхээр ахиц дэвшил гаргаж буй улс орнуудын хувьд Тогтвортой хөгжлийн эрүүл мэндтэй холбоотой бусад зорилтуудад хүрэхэд хялбар болж байна.	

БҮЛЭГ 1. 2019 ОНЫ ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ӨДРИЙН ТУХАЙ

1.1 Танилцуулга

2019 онд Дэлхийн эрүүл мэндийн өдрийг “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг онцлох жил” сэдвийн хүрээнд зохион байгуулж байна. Энэ өдрийг 2018 онд Астана хотод зохион байгуулсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ” сэдэвт олон улсын хурал болон 2019 оны 9–р сард Нью–Йорк хотод болох “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт” сэдэвт НҮБ–ын Дээд хэмжээний уулзалтын хоорондох цаг мөчид тэмдэглэж байгаагаараа онцлогтой. Энэ нь бид бүхэнд Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт (БНЭМХ)–д хүрэхэд ялангуяа, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чухлыг онцолсон “Бүх нийтийн эрүүл мэндийн төлөө” гэсэн уриаг илүү хүчтэйгээр дахин баталгаажуулах боломж олгож байна.	Япон улсын Токио хотноо 2017 онд тус улсын Засгийн газар, Дэлхийн банк, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, НҮБ–ын Хүүхдийн сан, ЖАЙКА зэрэг байгууллагууд оролцож, зохион байгуулсан “Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт” форумгаар Токиогийн тунхаглалыг баталж, БНЭМХ–д хүрэхэд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг тууштай мөрдөхийг уриалсан. Хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим гэдэг нь хүмүүсийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, тэдний дуу хоолойг тусгасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний загварыг бий болгож, хүргэх юм (Токиогийн тунхаглал: БНЭМХ, 2017).
Дэлхийн эрүүл мэндийн өдрийн үндсэн чиглэл нь тэгш байдал, эв санааны нэгдэл бөгөөд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг хангахын тулд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш бус байдал, санхүүгийн эрсдэлтэй холбоотой асуудлуудыг хөндөнө.	Энэ жилийн Дэлхийн эрүүл мэндийн өдрийг тэмдэглэх зорилго нь БНЭМХ, түүний үндэс суурь болох эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний ач холбогдлын талаарх ойлголтыг сайжруулахад оршиж байна. Мөн бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн ажилтнууд, иргэдийн зүгээс БНЭМХ–д хүрэх бодит үйлдэл хийх алхамыг идэвхжүүлэх юм.

1.2 Гол мессежүүд

- Эрүүл мэнд нь хүний эрхийн асуудал; одоо бүх нийтийн эрүүл мэндийн төлөө анхаарал хандуулах цаг мөн.
- Дэлхийн хүн амын тал хувь нь хэрэгцээтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ авч чадахгүй байсаар байна.
- Ойролцоогоор 100 сая хүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахдаа төлбөр төлж байгаагийн улмаас туйлын ядууралд өртөж байна.
- Энэ хүмүүс хэн бэ, бид тэр хүмүүст хэрхэн тусалж чадах вэ? Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс хэн орхигдоод байгааг олж мэдэхийн тулд нас, хүйс, орлого, амьдарч буй газар, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжид нөлөөлдөг бусад хүчин зүйлсээр ангилсан мэдээлэл шаардлагатай байна.
- Хүчирхэг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ бүхий тогтолцоо нь үр ашигтай, чанартай тусламж үйлчилгээг үзүүлж, улмаар хүн амын эрүүл мэндийг сайжруулна.
- Эрүүл мэндийн анхан шатны чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээ нь бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын суурь мөн.
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ нь хувь хүмүүс, гэр бүл, олон нийтийн амьдарч, ажиллаж буй газартай нь аль болох ойрхон байршиж, хүний амьдралын туршид эрүүл мэндийг дэмжихээс урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээх, хөнгөвчлөх хүртэлх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний дийлэнх хэсгийг үзүүлдэг эрүүл мэндийн тогтолцоотой харьцах эхний цэг юм.
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний цөм нь зөвхөн нэг өвчин, эмгэгийг эмчлэх бус, хүмүүсийн эрүүл мэндээ сайжруулах, сайн сайхан байхад нь туслах, халамж үйлчилгээ үзүүлэх юм.
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ нь мэргэжлийн олон талт багт суурилсан үйл ажиллагааг дэмжиж, иргэдийн хэрэгцээ, үнэлэмж, сонголтыг хүндэтгэсэн байна.
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ нь нийгмийн эмзэг, орхигдсон хүн амын бүлгүүдэд чиглэсэн стратегийг баримтлах замаар хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг хангана.
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ нь зардлын хувьд үр дүнтэй, тэгш байдлыг хангасан тусламж үйлчилгээ үзүүлэх арга зам бөгөөд улс орнуудад Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад

чиглэсэн ахиц дэвшил гаргахад нь гол дэмжлэг болно.

- Аюултай, чанаргүй эрүүл мэндийн үйлчилгээ нь жил бүр хэдэн их наяд доллартай тэнцэхүйц зардлыг урсгаж, иргэдийн амьдралыг сүйтгэж байна. Иймээс дэлхий нийтээрээ эрүүл мэндийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахын төлөө илүү ихийг хийх шаардлагатай.
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлүүлэгчидтэйгээ харилцан итгэлцсэн, тасралтгүй харилцаа холбоотой байж, тэдний эрүүл мэндийн түүхийг сайн мэддэгээрээ тэдэнд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулж, зардлыг хэмнэдэг.
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлэх хүрээний хүн амынхаа уламжлал, түүх соёл, зан заншил, дадал хандлагыг сайн мэдэх учраас өвчний дэгдэлт, онцгой тохиолдлын үед зайлшгүй шаардлагатай бэлэн байдлыг хангуулж чаддаг.
- Бүх нийтийн эрүүл мэндийн төлөөх үйлсийг бодит ажил хэрэг болгоход: хувь хүмүүс, иргэд, олон нийтэд эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгосноор тэд өөрсдийн болон гэр бүлийнхээ эрүүл мэндийн төлөө анхаардаг байх; эрүүл мэндийн чадварлаг ажилтнууд чанартай, хүн төвтэй тусламж үйлчилгээ үзүүлдэг байх; бодлого боловсруулагч нар эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийх чин хүсэл, эрмэлзлэлтэй байх шаардлагатай байна.

1.3 Үйл хэрэгт уриалан дуудах нь

Нийт хүн ам:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртэх нь таны болоод танай гэр бүлийн гишүүдийн эрх юм. Хүн бүр эрүүл



Зураг 1. Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын малчин айл өвөөлжөөндөө байгаа нь

мэндийн чанартай тусламж үйлчилгээг хүртэх эрхтэй гэдгийг удирдагч, манлайлагчиддаа хэлбэ.

Өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэндийг хамгаалахын төлөө шаардлагатай мэдээллээр хангагдах, дэмжлэг авах талаар эрүүл мэндийн ажилтнуудтайгаа ярилцаарай.

Эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ бидний эрүүл мэнд, улс орны эдийн засгийн хөгжил, нийгэмд сайнаар нөлөөлнө. Улс орнуудын удирдагч, манлайлагч нарт бүх нийтийн эрүүл мэндийн төлөөх зорилтыг бодит үйл хэрэг болгохыг уриалъя.

Эрүүл мэндийн ажилтан:

Эрүүл мэндийн ажилтан Та үйлчлүүлэгчийнхээ дуу хоолой юм. Хамт олонтойгоо нэгдэж, бүх нийтийн эрүүл мэндийн төлөөх үйлсийг дэмждэг гэдгээ удирдагч, манлайлагчиддаа дуулгаарай.

Эрүүл мэндийн ажилтан танд хүн амдаа эрүүл мэндийн чанартай тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх, улмаар тэдний

БҮЛЭГ 2. БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАМРАЛТ

2.1 Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт гэж юу вэ?

Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт гэдэг нь хүн бүр эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг хэрэгцээтэй үедээ, хаана амьдарч байгаагаас үл хамааран санхүүгийн хүндрэлгүйгээр авах боломжтой байхыг хэлнэ. Энэ нь эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх, хөнгөвчлөх зэрэг хүний амьдралын туршид шаардлагатай тусламж үйлчилгээг бүрэн хэмжээгээр агуулсан бөгөөд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүчирхэг тогтолцоонд суурилсан байдаг.

БНЭМХ нь хүн амын өвчлөл, нас баралтын үндсэн шалтгаанд чиглэсэн тусламж үйлчилгээг хүн бүр хүртээмжтэйгээр авах боломжоор хангах, тусламж үйлчилгээний чанар нь иргэдийн эрүүл мэндийг сайжруулахад хангалттай сайн байхад анхаардаг.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах үедээ халааснаасаа төлж буй төлбөрөөс улбаатай санхүүгийн хүндрэлээс иргэдийг хамгаалснаар тэднийг ядууралд өртөх эрсдэлийг бууруулна. Учир нь гэнэтийн өвчин эмгэгийн улмаас хадгаламжаа шавхах, хөрөнгөө зарах эсвэл зээл авах зэргээр санхүүгийн сүйрэлд өртдөг.


амьдралыг өөрчлөх хүч чадал, эрх мэдэл бий. Иргэдийг эрүүл мэндээ хамгаалах чадвартай болгоё. Иргэдийнхээ эрүүл мэндийн хэрэгцээг судлах, эрүүл байхад хэрэгтэй зүйлсийг зааж сургахад та гол үүрэгтэй.

Бодлого боловсруулагч:

Эрүүл мэнд бол улс төрийн сонголт юм. Засгийн газрын бүх бодлогод эрүүл мэндийн асуудлыг тусгахад анхаараарай.

БНЭМХ–д бодит ахиц дэвшил гаргахад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд илүү их хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Та үүнийг хийж чадна.

Энэ жил Та эрүүл мэндийн мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг сайжруулах талаар амлалт ав, тэгснээр нөөцөө зөв байршуулж, хамгийн хэрэгцээтэй газар нь өөрчлөлт хийж чадна.



Дүрслэл 1. Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын суурь нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ юм

2.2 Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт нь ... гэсэн үг биш

- БНЭМХ нь зардлаас үл хамааран эрүүл мэндийн бүхий л үйлчилгээнд үнэгүй хамрагдана гэсэн үг биш бөгөөд ямар ч улс орны хувьд бүх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх боломжгүй юм.
- БНЭМХ нь зөвхөн эрүүл мэндийн санхүүжилтын асуудал биш. Энэ нь эрүүл мэндийн тогтолцооны бүхий л бүрэлдэхүүн хэсгүүдийг хамарна. Үүнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, хүн хүч, барилга байгууламж, харилцаа холбооны сүлжээ, эрүүл мэндийн технологи, мэдээллийн тогтолцоо, чанарын баталгаажуулалтын механизм, засаглал, хууль тогтоомж зэрэг багтана.
- БНЭМХ нь зөвхөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамгийн наад захын багц бус, харин нөөц бололцоо нэмэгдэхийн хэрээр эрүүл мэндийн үйлчилгээний хамралт, санхүүгийн хамгаалалтыг улам өргөтгөх үйл явц юм.
- БНЭМХ нь зөвхөн хувь хүний эмчилгээ үйлчилгээнээс гадна нийгмийн эрүүл мэндийн асуудлыг хамардаг. Цаашилбал, БНЭМХ нь эрүүл мэндээс өргөн хүрээтэй асуудал бөгөөд бүх салбарын оролцоо чухал юм.

2.3 Улс орнууд бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэхэд хэрхэн ахиц гаргах вэ?

Улс орнуудад БНЭМХ–д чиглэсэн ахиц дэвшлүүд гарсаар байна. Бүх улс орнууд тодорхой ахиц дэвшил гаргаж, ололт амжилтаа бататгах боломжтой. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг уламжлалт байдлаар хүртээмжтэй, хямд төсөр

үзүүлдэг улс орнуудад хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ шаардлага асар ихээр нэмэгдэж, тусламж үйлчилгээний зардлын өсөлтийг гүйцэхэд ихээхэн хүндрэлтэй тулгарч байна.

Иймд, тухайн улс орон эрүүл мэндийн тогтолцоогоо бэхжүүлэх шаардлагатай бөгөөд үүнд санхүүжилтын оновчтой, тогтвортой бүтэц чухал байна. ДЭМБ–ын судалгаанаас харахад хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээний зардлын ихэнхийг халааснаасаа төлдөг тогтолцоотой нөхцөлд орлого багатай, эмзэг бүлгийнхэн шаардлагатай тусламж үйлчилгээг авах боломжгүйд хүрч, тэр ч байтугай чинээлэг иргэдийн хувьд урт хугацааны, архаг хүнд өвчний үед санхүүгийн хүндрэлд өртөх эрсдэлтэй байна. Албан журмын санхүүжилтын эх үүсвэрээс сан бүрдүүлснээр (албан журмын даатгалын шимтгэл гэх мэт) хүн амыг эрүүл мэндтэй холбоотой санхүүгийн эрсдэлээс хамгаалах боломжтой.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн үр нөлөөг дээшлүүлэхэд эрүүл мэндийн ажилтнуудын хүн төвтэй цогц тусламж үйлчилгээг чанартай үзүүлэх чадавх болон тусламж үйлчилгээний хүртээмж, хүрэлцэхүйц байдал чухал ач холбогдолтой.

Дэлхий нийтээрээ эрүүл мэндийн анхан шатны чанартай тусламж үйлчилгээнд хөрөнгө оруулах нь БНЭМХ–д хүрэх тулгын чулуу юм. ЭМАШТУ үзүүлэгчийн тогтвор суурьшлыг хангах, чадавхийг сайжруулахад хөрөнгө оруулалт хийх нь нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хамгийн үр дүнтэй арга зам. Мөн сайн засаглал, худалдан авалт, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлт, эрүүл мэндийн технологи, мэдээллийн тогтолцооны уялдаатай үйл ажиллагаа зэрэг нь бусад чухал бүрэлдэхүүн хэсгүүд юм.



Зураг 2. Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын бага эмч цаатан иргэдийн дунд эрүүл мэндийн үзлэг хийж байгаа нь

ЭМАШТУ нь зөвхөн тухайн өвчнийг тойрсон асуудал бус, харин эрүүл мэндийн хэрэгцээнд үндэслэн тухайн хүний амьдралын туршид тусламж үйлчилгээ үзүүлэхэд чиглэнэ. ЭМАШТУ нь хүртээмжтэй байснаар хүмүүсийн өдөр тутмын амьдралын орчинд ойртож, эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэхээс эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээх, хөнгөвчлөх хүртэлх цогц тусламж үйлчилгээг авах боломжийг олгодог.

ЭМАШТУ–ний үндэс бол нийгмийн шударга ёс, тэгш байдлыг хангахад орших бөгөөд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25–р зүйлд заасанчлан хүний суурь эрхийг эрүүл мэндийн хүрч болох стандартын дээд түвшинд хангадаг: “Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй [...]”.

ЭМАШТУ–ний тухай үзэл баримтлал, ойлголтыг эргэн харж, дахин тодорхойлсоор ирлээ. Зарим нөхцөлд амбулаторийн тусламж үйлчилгээ эсвэл хувь хүнд ЭМАШТУ–г үзүүлэх хэмээн ойлгож байв. Нэг талаар ЭМАШТУ–г бага орлоготой хүн амд чиглэсэн эрүүл мэндийн тэргүүлэх арга хэмжээ гэж тодорхойлсон байдаг (мөн эрүүл мэндийн анхан шатны сонгомол тусламж үйлчилгээ ч хэмээн нэрлэдэг). Нөгөө талаар ЭМАШТУ–г хүний хөгжлийн чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн ойлгож, эдийн засаг, нийгэм, улс төрийн асуудлуудад анхаарлаа хандуулж байв.

ДЭМБ–аас гурван бүрэлдэхүүн хэсэгтэй, хоорондоо нягт уялдаатай тодорхойлолтыг гаргасан. Үүнд:

- Хүний амьдралын туршид эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг цогцоор нь үзүүлэх замаар эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэх, хувь хүн, гэр бүлд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стратегийн ач холбогдлоор нь эрэмбэлэх, эрүүл мэндийн цогц үйлчилгээний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох анхан шатны тусламж ба нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг хүн амд хүргэх;
- Бүх салбарын нотолгоонд тулгуурласан нийгмийн бодлого, үйл ажиллагаагаар дамжуулан эрүүл мэндийг (нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүмүүсийн зан төлөв, зан үйлийг оролцуулан) илүү өргөн хүрээтэй, системтэй авч үзэж, шийдвэрлэх;
- Хувь хүн, гэр бүл, олон нийтийн эрүүл мэндийг дээшлүүлэх үүднээс тэдэнд эрүүл мэндийн боловсрол олгож, тэднийг чадавхжуулах замаар эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих, хамгаалах бодлогыг дэмжигч байх, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг

хамтран хөгжүүлэгч байх, улмаар өөрөө өөртөө анхаарал тавьдаг, бусдыг асран халамжлагч байх.

3.2 Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ яагаад чухал вэ?

ЭМАШТУ–г шинэчилж, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дээшлүүлэх хүчин чармайлтын төвд тавих нь дараах гурван үндсэн шалтгаантай. Үүнд:

- Хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдалд нөлөөлж буй эдийн засаг, технологи, хүн ам зүйн хурдацтай өөрчлөлтөд хариу үзүүлэх оновчтой механизм нь ЭМАШТУ юм. Дэлхийн түвшинд 1990–ээс 2010 он хүртэл хүүхдийн эндэгдэл буурсны тэн хагас нь эрүүл мэндийн бус салбарын хүчин зүйлс (тухайлбал, ус, эрүүл ахуй, боловсрол, эдийн засгийн өсөлт гэх мэт) нөлөөлснийг саяхны судалгааны үр дүнд дурджээ. ЭМАШТУ–нд суурилсан хандлага нь эрүүл мэнд, сайн сайхан байдлыг тодорхойлогч нийгэм, эдийн засаг, байгаль орчин, арилжааны хүчин зүйлсийг шийдвэрлэдэг олон талт хамтын ажиллагаанд чухал үүрэгтэй.



Зураг 3. Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумын бага эмч, вакцины сувилагч нар цаатан иргэдэд явуулын тусламж үйлчилгээг хүргэхээр явж буй нь

- ЭМАШТУ нь бидний эрүүл мэнд, сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж буй үндсэн шалтгаан, эрсдэлийг шийдвэрлэхэд үр дүнтэй, үр өгөөжтэй арга зам болох нь батлагдсан. ЭМАШТУ–ний чанар сайн байх тусам эрүүл мэндийн нийт зардал буурч, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх нь багассанаар үр ашиг нэмэгддэг болохыг нотоллоо. Ийм учраас ЭМАШТУ–д оруулж буй хөрөнгө оруулалт нь улам үнэ цэнэтэй болж байна. Өсөн нэмэгдэж буй эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж шийдвэрлэхэд эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх бодлого, олон нийтэд чиглэсэн шийдэл, хүн төвтэй эрүүл мэндийн үйлчилгээний

нэгдмэл байдлыг хангахуйц олон салбарыг хамарсан арга замыг шаардаж байна. Мөн эрүүл мэндийн аюулгүй байдлыг сайжруулах, халдварын цар тахал, нянгийн тэсвэржилт зэрэг асуудлыг авч үзэх гол элементүүд нь ЭМАШТУ–ний бүхэлдэхүүн хэсгүүдэд багтдаг. Тухайлбал, олон нийтийн оролцоо, боловсрол, эмийн зохистой жор бичилт, тандалт судалгаа зэрэг зайлшгүй шаардлагатай нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнүүд орно. Алслагдмал, хөдөө, орон нутгийн эрүүл мэндийн анхан шатны байгууллагыг бэхжүүлэхэд эрүүл мэндийн тогтолцооны хөрвөх чадварыг сайжруулах нь чухал.

- ЭМАШТУ–г бэхжүүлэх нь эрүүл мэндийн талаарх Тогтвортой хөгжлийн зорилт, БНЭМХ–д хүрэхэд ихээхэн ач холбогдолтой. Энэ нь эрүүл мэндийн зорилтоос гадна ядуурал, өлсгөлөн, боловсрол, жендэрийн тэгш байдал, цэвэр ус, эрүүл ахуй, хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн өсөлт, тэгш бус байдал, цаг уурын өөрчлөлтийг бууруулах зэрэг бусад зорилтуудыг биелүүлэхэд хүртэл хувь нэмрээ оруулна.

3.3 Астанагийн тунхаглал

Алма–Атагийн түүхэн тунхаглалыг баталснаас хойш 40 жилийн дараа буюу 2018 оны 10 сарын 25–26–нд Бүгд Найрамдах Казахстан улсын Астана хотод тус улсын Засгийн газар нь ДЭМБ болон НҮБ–ын Хүүхдийн Сантай хамтран “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ” сэдвийн дор олон улсын хурал зохион байгуулсан. Хурлын үеэр улс орнуудын төрийн тэргүүн, эрүүл мэндийн сайд,



Дүрслэл 2. Астанагийн тунхаглал

эрүүл мэндийн удирдах ажилтнууд, эрдэмтэн судлаачид, түншүүд, иргэний нийгмийнхэн Астанагийн тунхаглалаар Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын суурь болох ЭМАШТУ–г санал нэгтгэйгээр дахин баталгаажууллаа. Энэхүү тунхаглал нь Засгийн газар, төрийн бус болон мэргэжлийн байгууллагууд, сургалт эрдэм шинжилгээ, олон улсын эрүүл мэнд болон хөгжлийн байгууллагуудын зүгээс ЭМАШТУ–ний талаарх улс төрийн амлалтыг шинэчлэхэд чиглэсэн юм.

Астанагийн тунхаглалаар дараах дөрвөн үндсэн чиглэл бүхий улс төрийн амлалтыг гаргасан. Үүнд:

1. Бүх салбарын бодлогод эрүүл мэндийн асуудлыг тусгах улс төрийн зоригтой сонголт хийх

Бид хүн бүрийн эрүүл мэндийн хүрч болохуйц хамгийн дээд стандартыг хүртэх эрхийг дэмжих, хамгаалах Засгийн газрын үндсэн үүрэг, хариуцлагыг дахин баталгаажуулж байна. ЭМАШТУ–г бэхжүүлэхэд холбогдох талуудыг татан оролцуулах, орон нутагт иргэд, олон нийтийг чадавхжуулах замаар салбар дундын хамтын ажиллагаа, БНЭМХ–ыг дэмжинэ. Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх эдийн засаг, нийгэм, орчны хүчин зүйлсэд анхаарал хандуулж, бүх салбарын бодлогод эрүүл мэндийн асуудлыг тусгах замаар эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах болно. Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ил тод, нээлттэй байдлыг дэмжих, засаглалын оролцоог хангах замаар хэнийг ч орхигдуулахгүйгээр бүх нийтийн эрүүл мэндийн төлөөх зорилтод хүрэхийн тулд илүү олон оролцогч талуудыг оролцуулна. Эрүүл мэндийн тогтолцоо, эрүүл мэндийн үр дүнд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсээс зайлсхийх эсвэл бууруулахыг хичээнэ. Онцгой байдлын үед БНЭМХ–ын суурь болох ЭМАШТУ–г цогц, нэгдмэл хандлагыг ашиглан өргөжүүлэх замаар хүмүүнлэгийн зарчмуудад нийцсэн нэн шаардлагатай ба тасралтгүй тусламж үйлчилгээг үзүүлнэ. Бид ЭМАШТУ–г бэхжүүлэх үүднээс хүн хүчний болон бусад нөөцийн хангалт, хуваарилалтыг зохистойгоор хийнэ. ЭМАШТУ–нд бодитойгоор дэмжлэг үзүүлсэн төр засаг, манлайлагчдад гүнээ талархах болно.

2. Тогтвортой эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бий болгох

Бид ЭМАШТУ–г улс үндэстний хууль эрх зүйн орчин, нөхцөл байдал, тэргүүлэх асуудлуудтай уялдуулан хөгжүүлнэ. Бид ЭМАШТУ–нд хөрөнгө оруулалт хийх замаар эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ. Бид нийгмийн эрүүл мэндийн нэн шаардлагатай арга хэмжээг тэргүүн эгнээнд авч үзэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах анхны цэг болох анхан шатны тусламж үйлчилгээний чадавх, дэд бүтцийг бэхжүүлнэ. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлийг



Зураг 4. УБ хотын Баянзүрх дүүргийн 20–р хорооны өрхийн эмч, мэргэжилтнүүд эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж үйлчилгээ үзүүлж байгаа нь

тэргүүлэх эгнээнд тавьж, эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээх, хөнгөвчлөх зэрэг цогц тусламж үйлчилгээг хүний амьдралын туршид үзүүлнэ. ЭМАШТУ–г цогцоор үзүүлэх гэдэг нь дархлаажуулалт, эрт илрүүлэг, халдварт ба халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналт, эх, нярай, хүүхэд өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих, сайжруулах, сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэргийг багтаах ба гэхдээ эдгээрээр хязгаарлахгүй. ЭМАШТУ бол хүртээмжтэй, тэгш, аюулгүй, чанартай, цогц, үр ашигтай, хүлээн зөвшөөрөгдсөн, хүрэлцэхүйц байх шаардлагатай. Мөн ЭМАШТУ–г хүн төвтэй, жендэрийн мэдрэмжтэй, тасралтгүй байдлаар үзүүлнэ.

3. Иргэд, олон нийтийг чадавхжуулах

Бид эрүүл мэндэд үр нөлөөтэй бодлого, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд хувь хүн, гэр бүл, олон нийт, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог дэмжинэ. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дэмжиж, иргэд, олон нийтийн хүлээлтэд нийцсэн эрүүл мэндийн үнэн, зөв мэдээллээр хангаж ажиллана. Эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн зааврын дагуу хувь хүн өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмших болон нөөцийг ашиглахад дэмжлэг үзүүлнэ. Бид эв санааны нэгдэл, ёс зүй, хүний

эрхийг хамгаална. Бид олон нийтийн өөртөө эзэн байхыг дэмжиж, илүү олон хүнийг эрүүл байлгах, эрүүл орчинд амьдрах нөхцлөөр хангах төр, хувийн салбарын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулна.

4. Үндэсний бодлого, стратеги, төлөвлөгөөг дэмжигч талуудын үйл ажиллагааг уялдуулах

БНЭМХ–д чиглэсэн хүчирхэг, тогтвортой ЭМАШТУ–г бий болгох үүднээс хүн төвтэй, жендэрт суурилсан хандлага бүхий үндэсний хэмжээний бүх салбарыг хамарсан бодлого, стратеги, төлөвлөгөөтэй уялдуулах зорилгоор оролцогч талуудыг, тухайлбал, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны байгууллагууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, үндэсний ба олон улсын түншлэгчид, сангууд, хувийн хэвшил, итгэл үнэмшилд суурилсан болон бусад байгууллагуудыг хамтран ажиллахыг Бид уриалан дуудаж байна. Оролцогч талууд нь ЭМАШТУ–нд хангалттай хүн хүч, техник технологи, санхүүжилт, мэдээллийн нөөцөөр тусалж чадна. Энэхүү тунхаглалыг хэрэгжүүлэхдээ улс үндэстнүүдийн бие даасан байдал, хүний эрхийг дээдлэхийн сацуу түншлэл, үр дүнтэй хөгжлийн хамтын ажиллагаа, мэдлэг, сайн туршлагаа хуваалцах замаар хамтран ажиллах болно.



Зураг 5. УБ хотын Хан–Уул дүүргийн ЗДТГ, хорооны дарга нар, иргэдийн төлөөлөлтэй хамтран өрхийн эмч, мэргэжилтнүүд алслагдсан, эмзэг бүлгийн өрх, иргэдийнхээ нийгмийн асуудлыг тодорхойлж байгаа нь

1. Declaration of Astana, WHO website: <https://www.who.int/primary-health/conference-phc/declaration>
2. Health for All, Universal health coverage with a focus on primary health care, WHD 2019 Campaign plan
3. Key messages for World Health Day 2019, WHO March 2019
4. Primary health care fact sheet, 27 February 2019, WHO website: <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/primary-health-care>
5. Universal health coverage fact sheet, 24 January 2019, WHO website: [https://www.who.int/news-room/fact-sheets/detail/universal-health-coverage-\(uhc\)](https://www.who.int/news-room/fact-sheets/detail/universal-health-coverage-(uhc))
6. Tokyo declaration on Universal Health Coverage, 2017, WHO website:
7. A vision of primary health care in the 21st century, towards universal health coverage and the sustainable goals, WHO and UNICEF, 2018
8. World health day 2019, WHO website: <https://www.who.int/westernpacific/news/events/detail/2019/04/07/western-pacific-events/world-health-day-2019>
9. Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт: Хэнд ч, хаана ч мэдээллийн товхимол, ДЭМБ 2018





**World Health
Organization**

Representative Office
for Mongolia